



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн  
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СЭА-2024/236-НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2024 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит" ХХК Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ц.РЭНЦЭННОРОВ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/236/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 4 дүгээр түвшинд үнэлэгдэж, урамшуулалд 32,722.3 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь

018020153

гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 83.7 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>274,276,789.20</b>	<b>694,898,338.03</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>65,720,736.66</b>	411,365,167.44
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>65,720,736.66</b>	411,365,167.44
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>65,720,736.66</b>	411,365,167.44
31211	Төрийн сангийн харилцах	65,720,736.66	411,365,167.44
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>208,556,052.54</b>	<b>283,533,170.59</b>
<b>3510</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>16,788,241.00</b>	<b>16,587,810.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	16,374,650.00	16,374,650.00
35130	Эм боох материал	413,591.00	213,160.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>190,322,811.54</b>	<b>266,945,360.59</b>
35410	Бичиг хэргийн материал	-	90,000.00
35420	Аж ахуйн материал	188,320,311.54	213,738,644.35
35440	Түлш, шатах тослох материал	-	100,000.00
35460	Хүнсний материал	2,002,500.00	4,994,270.00
35470	Бусад хангамжийн материал	-	12,522,446.24
35600	Мал амьтад	1,445,000.00	35,500,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,760,373,065.09</b>	<b>5,338,406,279.44</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>4,760,373,065.09</b>	<b>5,338,406,279.44</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>4,401,429,065.09</b>	<b>4,988,743,529.46</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,846,306,301.50	5,515,620,938.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(855,652,311.80)	(1,036,005,662.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,090,500.00	21,090,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,090,500.00)	(21,090,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	645,165,951.39	658,413,285.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	(347,344,803.88)	(320,681,276.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	234,674,114.85	301,121,812.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(154,306,445.56)	(155,902,013.02)
39217	Ном	32,586,258.59	26,176,444.84
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>358,944,000.00</b>	<b>349,662,749.98</b>
39301	Програм хангамж	14,580,000.00	15,085,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,460,000.00)	(12,246,250.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	348,959,000.00	348,959,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(2,135,000.00)	(2,135,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,034,649,854.29</b>	<b>6,033,304,617.47</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>982,800.00</b>
<b>41</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	-	<b>982,800.00</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>982,800.00</b>
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	-	982,800.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,034,649,854.29</b>	<b>6,032,321,817.50</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,034,649,854.29</b>	<b>6,032,321,817.50</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,128,048,996.21	2,128,048,996.21
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,128,048,996.21	2,128,048,996.21
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(937,738,038.85)</b>	<b>59,933,924.33</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(5,986,926,763.14)	(937,738,038.85)
51220	Тайлант үеийн үр дүн	5,049,188,724.29	997,671,963.18

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,844,338,896.93	3,844,338,896.93
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,034,649,854.29</b>	<b>6,033,304,617.47</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>7,984,907,347.69</b>	<b>4,344,878,711.89</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,268,553,916.07</b>	<b>947,327,378.14</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>5,268,553,916.07</b>	<b>947,327,378.14</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>59,421,190.00</b>	<b>947,327,378.14</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,501,000.00	13,037,648.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,920,190.00	40,167,200.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,967,486,980.23	815,460,380.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	241,645,745.84	78,662,150.14
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,716,353,431.62</b>	<b>3,397,551,333.75</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,227,876,500.00</b>	<b>3,006,304,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,227,876,500.00	3,006,304,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>33,239,650.00</b>	<b>-</b>
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,909,200.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,330,450.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>455,237,281.62</b>	<b>391,247,233.75</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	455,237,281.62	391,247,233.75
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,935,083,623.40</b>	<b>3,337,158,695.96</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,935,083,623.40</b>	<b>3,337,158,695.96</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,754,952,013.40</b>	<b>3,178,635,720.96</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,664,025,905.32</b>	<b>2,045,650,443.63</b>
210101	Үндсэн цалин	1,155,231,313.28	1,375,212,519.03
210102	Нэмэгдэл	421,486,561.04	590,599,745.96
210104	Урамшуулал	87,308,031.00	79,838,178.64
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>207,416,343.20</b>	<b>255,874,709.54</b>
210201	Тэтгэврийн даатгал	143,563,080.81	178,356,543.51
210202	Тэтгэмжийн даатгал	16,891,019.77	21,012,277.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,307,505.73	16,429,023.03
210204	Ажилгүйдлийн даатгал	3,053,394.33	3,634,661.06
210205	Эрүүл мэндийн даатгал	30,601,342.56	36,442,204.07
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>354,578,302.44</b>	<b>369,747,233.75</b>
210301	Гэрэл, цахилгаан	52,358,335.44	34,337,108.95
210302	Түлш, халаалт	172,592,641.00	203,168,718.80
210303	Цэвэр, бохир ус	129,627,326.00	132,241,406.00

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,079,857.80</b>	<b>-</b>
210401	Бичиг хэрэг	252,200.00	-
210402	Тээвэр, шатахуун	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-
210404	Ном, хэвлэл	1,260,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	443,800.00	-
210408	Бараа материал акталсны зардал	15,123,857.80	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>76,820,344.00</b>	<b>68,257,616.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	76,820,344.00	68,257,616.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>28,732,950.00</b>	<b>21,500,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	27,732,950.00	21,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>-</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,198,420.00</b>	<b>21,349,181.05</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,606,400.00	9,396,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,592,020.00	11,952,581.05
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>390,099,890.64</b>	<b>396,256,536.99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,536,615.50	56,196,191.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,924,330.00	26,888,533.09
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	314,638,945.14	313,171,812.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>180,131,610.00</b>	<b>158,522,975.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>180,131,610.00</b>	<b>158,522,975.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	158,499,410.00	137,253,475.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,632,200.00	21,269,500.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>5,049,823,724.29</b>	<b>1,007,720,015.93</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>635,000.00</b>	<b>10,048,052.75</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	635,000.00	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	10,048,052.75
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>5,049,188,724.29</b>	<b>997,671,963.18</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,775,774,621.62</b>	<b>3,450,756,781.75</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>59,421,190.00</b>	<b>53,204,848.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>59,421,190.00</b>	<b>53,204,848.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>59,421,190.00</b>	<b>53,204,848.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37,501,000.00	13,037,648.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,920,190.00	40,167,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,716,353,431.62</b>	<b>3,397,551,333.75</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,227,876,500.00</b>	<b>3,006,304,100.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,227,876,500.00	3,006,304,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>33,239,650.00</b>	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,909,200.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,330,450.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>455,237,281.62</b>	<b>391,247,233.75</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	455,237,281.62	391,247,233.75
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,602,528,854.96</b>	<b>3,019,319,050.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,602,528,854.96</b>	<b>3,019,319,050.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,422,577,514.96</b>	<b>2,857,705,925.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,663,401,821.97</b>	<b>2,045,650,443.63</b>
210101	Үндсэн цалин	1,155,028,695.10	1,365,018,279.24
210102	Нэмэгдэл	421,124,436.20	592,890,714.39
210104	Урамшуулал	87,248,690.67	87,741,450.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>208,040,426.55</b>	<b>255,874,709.54</b>
210201	Тэтгэврийн даатгал	143,917,704.30	178,356,543.51
210202	Тэтгэмжийн даатгал	16,907,486.19	21,012,277.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,508,583.04	16,429,023.03
210204	Ажилгүйдлийн даатгал	3,058,077.62	3,634,661.06
210205	Эрүүл мэндийн даатгал	30,648,575.40	36,442,204.07
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>354,578,302.44</b>	<b>369,747,233.75</b>
210301	Гэрэл, цахилгаан	52,358,335.44	34,337,108.95
210302	Түлш, халаалт	172,592,641.00	203,168,718.80
210303	Цэвэр, бохир ус	129,627,326.00	132,241,406.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,956,000.00</b>	-
210401	Бичиг хэрэг	252,200.00	-
210402	Тээвэр, шатахуун	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-
210404	Ном, хэвлэл	1,260,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	443,800.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>75,042,614.00</b>	66,986,736.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
210502	Хоол, хүнс	75,042,614.00	66,986,736.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>28,732,950.00</b>	<b>21,500,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	-
210604	Урсгал засвар	27,732,950.00	21,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-
210702	Дотоод албан томилолт	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,357,620.00</b>	<b>21,349,181.05</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,606,400.00	9,396,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,751,220.00	11,952,581.05
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>74,467,780.00</b>	76,597,622.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,283,130.00	52,056,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,184,650.00	24,541,622.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>179,951,340.00</b>	<b>161,613,125.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>179,951,340.00</b>	<b>161,613,125.00</b>
213205	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	158,319,140.00	140,343,625.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,632,200.00	21,269,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>173,245,766.66</b>	3,019,319,050.97
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>107,525,030.00</b>	<b>3,019,319,050.97</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>107,525,030.00</b>	<b>3,019,319,050.97</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>107,525,030.00</b>	<b>3,019,319,050.97</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	107,525,030.00	3,019,319,050.97
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(107,525,030.00)</b>	- 3,019,319,050.97
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>65,720,736.66</b>	- 2,587,881,320.19
19	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		65,720,736.66
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	65,720,736.66	411,365,167.44

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувьоролцооны нийт дүн
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,128,048,996.21	3,844,338,896.93	(937,738,038.85)	5,034,649,854.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,128,048,996.21	3,844,338,896.93	(937,738,038.85)	5,034,649,854.29
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлтбууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Өмчид гарсан өөрчлөлт				
Зарласан ногдол ашиг				
Тайлант үеийн үр дүн			997,671,963.18	997,672,563.18
2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,128,048,996.21	3,844,338,896.93	59,933,924.33	6,032,321,817.47

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,517,965,533.75</b>	<b>3,105,111,750.97</b>	<b>412,853,782.78</b>	<b>88.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,517,965,533.75</b>	<b>3,105,111,750.97</b>	<b>412,853,782.78</b>	<b>88.3</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,320,346,233.75</b>	<b>2,943,498,625.97</b>	<b>376,847,607.78</b>	<b>88.7</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,357,770,800.00</b>	<b>2,045,650,443.63</b>	<b>312,120,356.37</b>	<b>86.8</b>
210101	Үндсэн цалин	1,563,339,100.00	1,365,018,279.24	198,320,820.76	87.3
210102	Нэмэгдэл	689,850,600.00	592,890,714.39	96,959,885.61	85.9
210104	Урамшуулал	104,581,100.00	87,741,450.00	16,839,650.00	83.9
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>294,721,900.00</b>	<b>255,874,709.54</b>	<b>38,847,190.46</b>	<b>86.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	200,411,200.00	178,356,543.51	22,054,656.49	89.0
210202	Тэтгэмжийн даатгал	23,577,700.00	21,012,277.87	2,565,422.13	89.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,862,100.00	16,429,023.03	2,433,076.97	87.1
210204	Ажилгүйдлийн даатгал	4,715,500.00	3,634,661.06	1,080,838.94	77.1
210205	Эрүүл мэндийн даатгал	47,155,400.00	36,442,204.07	10,713,195.93	77.3
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>369,747,233.75</b>	<b>369,747,233.75</b>	-	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	34,337,108.95	34,337,108.95	-	100.0
210302	Түлш, халаалт	203,168,718.80	203,168,718.80	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	132,241,406.00	132,241,406.00	-	100.0
2105	<b>Нормативт зардал</b>	<b>75,984,500.00</b>	<b>66,986,736.00</b>	<b>8,997,764.00</b>	<b>88.2</b>
210502	Хоол, хүнс	75,984,500.00	66,986,736.00	8,997,764.00	88.2
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>21,500,000.00</b>	<b>21,500,000.00</b>	-	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	21,500,000.00	21,500,000.00	-	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>26,297,800.00</b>	<b>21,349,181.05</b>	<b>4,948,618.95</b>	<b>81.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,936,600.00	9,396,600.00	540,000.00	94.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,361,200.00	11,952,581.05	4,408,618.95	73.1

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>174,324,000.00</b>	<b>162,390,322.00</b>	<b>11,933,678.00</b>	<b>93.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	149,631,600.00	137,848,700.00	11,782,900.00	<b>92.1</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,692,400.00	24,541,622.00	150,778.00	<b>99.4</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>197,619,300.00</b>	<b>161,613,125.00</b>	<b>36,006,175.00</b>	<b>81.8</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>197,619,300.00</b>	<b>161,613,125.00</b>	<b>36,006,175.00</b>	<b>81.8</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	176,349,800.00	140,343,625.00	36,006,175.00	<b>79.6</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,269,500.00	21,269,500.00	-	<b>100.0</b>
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,517,965,533.75</b>	<b>3,450,756,181.75</b>	<b>1,488,615.34</b>	<b>98.1</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,006,304,100.00</b>	<b>3,006,304,100.00</b>	-	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,006,304,100.00	3,006,304,100.00	-	<b>100.0</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>391,247,233.75</b>	<b>391,247,233.75</b>	-	<b>100.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	391,247,233.75	391,247,233.75	-	<b>100.0</b>
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>120,414,200.00</b>	<b>53,204,848.00</b>	<b>1,488,615.34</b>	<b>97.3</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,247,000.00	13,037,648.00	27,209,352.00	<b>32.4</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,452,900.00	40,167,200.00	(25,714,300.00)	<b>277.9</b>
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	65,714,300.00		65,714,300.00	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		65,720,736.66	(65,720,736.66)	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		411,365,167.44	(411,365,167.44)	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>			-	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	122	113	9	
620001	Удирдах ажилтан	4	4	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	118	109	9	
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>1,100</b>	<b>1,546</b>	-	
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	1,100	1,546	-	
630001	Төрийн өмчит ЕБС	1,100	1,546	-	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь “Хамтаараа хөгжсөн зөв дадал хэвшилтэй хүүхэд болгон төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах нөхцөлийг бүрдүүлж, сурлагын хоцрогдлыг арилгах,
- Хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэн, цахим сан болон даалгаврын санг бүрдүүлж ашиглах,
- Багш бүр сургалтын арга хэлбэр, заах арга зүйгээ оновчтой сонгон заах,
- Багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагааг сайжруулж ажиллах.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 1 дүгээр сарын 06, 5 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон.*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:*
  1. *"ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх",*
  2. *"Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 998,655.4 мянган төгрөгөөр буюу 19.83 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	65,720.7	411,365.2	345,644.5

Авлага			
Бараа материал	208,556.1	283,533.2	74,977.1
Үндсэн хөрөнгө	4,760,373.1	5,338,406.3	578,033.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,034,649.9</b>	<b>6,033,304.6</b>	998,654.7
Өр төлбөр		982.8	982.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,034,649.9	6,032,321.8	997,671.9
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,034,649.9</b>	<b>6,033,304.6</b>	998,654.7

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 411,365.2 мянган төгрөг болж 345,644.5 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх “Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 283,533.2 мянган төгрөг болж 74,977.1 мянган төгрөгөөр өссөн нь БШУЯ-наас 21,319.2 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, БШУГ-аас 12,522.4 мянган төгрөгийн сурах бичиг, нас дэвшилтийн орлогоор 34,055.0 мянган төгрөгийн мал хүлээн авсан, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аас 6,808.4 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 2,512,1 мянган төгрөгийн бараа материал тус тус үнэ төлбөргүй орлого авснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,338,406.3 мянган төгрөг болж 578,033.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 85,792.7 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж худалдан авч, БШУЯ-наас 3,638.2 мянган төгрөгийн ном сурах бичиг, 9,972.0 мянган төгрөгийн сандал, 14,089.0 мянган төгрөгийн төгөлдөр хуур, Тэгш хамрах төслөөр 49,522.5 мянган төгрөгөөр сургалтын хэрэглэгдэхүүн, Сэлэнгэ ЗДТГ-аас лингафоны кабинетын 65,717.6 мянган төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, Япон улсын өвсний үндэс төслийн хүрээнд 465,850.3 мянган төгрөг бохирын шугамд, 203,464.4 мянган төгрөг цахилгааны засварт, ДЗОУБ-аас 3,206.4 мянган төгрөгөөр тэнхим тохижуулан үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 10 сарын 13-ны өдрийн 85 дугаар тогтоолоор 158,148.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 313,171.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 4,080,296.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 2,833,031.0 мянган төгрөг, нийт 6,913,327.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвийн санхүүжилтийг 1,073,991.9 мянган төгрөгөөр бууруулж 3,006,304.1 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 2,441,783.8 мянган төгрөгөөр бууруулж 391,247.2 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 54,699.9 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 65,714.3 мянган төгрөг нийт 3,517,965.5 мянган төгрөгөөр төсвийг эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 3,450,756.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 3,105,111.7 мянган төгрөгийг зарцуулж, 412,853.8 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,105,111.7 мянган төгрөг буюу 88.3 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалт 305,679.4 мянган төгрөг, сургалтын хэвийн үйл ажиллагаа 41,873.5 мянган төгрөг, гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн 12,786.2 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 36,006.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	6,544.5	6,544.5	-	100
2	80312 - Сургалт семинар	4,754.6	3,376.5	1,378.1	71
3	81605 - Эрүүл мэндийг дэмжих	9,071.0	3,815.0	5,256.0	42
4	81801 -үдийн цай хөтөлбөр	176,349.8	140,343.6	36,006.2	80
5	81806 -Дотуур байрны үйлчилгээ	102,355.4	94,090.3	8,265.1	92
6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	73,100.6	72,188.7	911.9	99
7	81823-Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	14,725.0	14,721.7	3.3	100
8	81834-Боловсролын стандарт, сургалтын	2,285,834.1	1,980,154.7	305,679.4	87
9	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	391,151.8	349,278.3	41,873.5	89
10	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	34,565.8	21,779.6	12,786.2	63
11	81848-Сурах бичгийн түрээс	9,936.6	9,396.6	540.0	95
12	83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	1,368.0	1,365.0	3.0	100

13	83603-Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	16,961.1	16,810.0	151.1	99
<b>Дүн</b>		<b>3,126,718.3</b>	<b>2,713,864.5</b>	<b>412,853.8</b>	87
14	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	391,247.2	391,247.2	-	100
<b>Нийт</b>		<b>3,517,965.5</b>	<b>3,105,111.7</b>	<b>412,853.8</b>	88.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул “Алтан тариа” ХХК, “Алтан есүй” ХХК, “”Өсөх эрдэнэт сүрэг” ХХК, Ирвэсийн хавцал” ХХК, “Сэлэнгэ баян уул” ХХК, “Цахим ертөнц” ХХК-иуд болон иргэн М.Мөнхцэцэг, Ц.Цэсэм, Д.Даваасүрэн, Г.Баярсайхан, Л.Энхчимэг, Д.Оюунчимэг нартай шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит” ХХК-ийн аудитор О.Чулуунбаатар, Ю.Уртнасан, чанарын хяналтыг захирал О.Бурмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Аав ээжийн тэнгэрлэг буян Аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,935,083.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 29,350.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 166 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх 278,705.2 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй учраас “Алтан тариа” ХХК, “Алтан есүй” ХХК, “Өсөх эрдэнэт сүрэг” ХХК, Ирвэсийн хавцал” ХХК, “Сэлэнгэ баян уул” ХХК, “Цахим ертөнц” ХХК-иуд болон иргэн М.Мөнхцэцэг, Ц.Цэсэм, Д.Даваасүрэн, Г.Баярсайхан, Л.Энхчимэг, Д.Оюунчимэг нартай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	15,183.2	1	15,183.2	100.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>15,183.2</b>	<b>1</b>	<b>15,183.2</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт **982.8** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

### **5.1 Албан шаардлага**

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас бараа ажил, үйлчилгээний бусад зардлын / цэвэрлэгээний материал / 982.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөр тооцоо, гүйлгээг гарахаас өмнө нь хянан баталгаажуулж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

